



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/828

Улаанбаатар хот

“Журам, маягт, загвар шинэчлэн батлах тухай”

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ын 1, 5, 6, 19, 41 дэх хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2004 оны “Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч шагнал бий болгох тухай” 199 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын албан хаагчид шагнал олгох журам”-ыг нэгдүгээр, “Засгийн газрын хүндэт тэмдэг”-ийн загварыг хоёрдугаар, “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны жуух бичиг”-ийн загварыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /О.Хуягцогт/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны “Журам, маягт, бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай” А/473 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Е.БААТАРБИЛЭГ

0619 02676

ловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 12-р сарын 28-ны өдрийн А.Т.А.аар тушаалын нэгдүгээр зардалт.

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарыг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан, онцгой амжилт гаргасан төрийн албан хаагч, Монгол Улсын болон гадаадын иргэнийг Засгийн газрын /цаашид “салбарын шагнал” гэх/ болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны шагнал /цаашид “яамны шагнал” гэх/-д нэр дэвшүүлэх, шагнаж урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. "Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал" олгох асуудлыг Засгийн газрын "Журам шинэчлэн батлах тухай" 2004 оны 124 дүгээр, "Д.Цэвэгмидийн нэрэмжит шагнал" олгох асуудлыг Засгийн газрын "Д.Цэвэгмидийн нэрэмжит шагнал бий болгох тухай" 2005 оны 101 дүгээр тогтоолоор баталсан журмаар тус тус зохицуулна.

Хоёр. Шагналын ангилал

2.1. Засгийн газрын шагнал нь дор дурдсан ангилалтай байна.

2.1.1. “Боловсролын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;

2.1.2. “Соёлын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг:

2.1.3. “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;

2.1.4. “Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг:

2.1.5. “Ардын авьяастан” хүндэт тэмдэг;

2.2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны шагнал нь дор дурдсан ангилалтай байна.

2.2.1. Яамны “Жуух бичиг”:

2.2.2. "Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч" тэмдэг, үнэмлэх:

Гурав. Шагнал олгох нөхцөл

3.1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарыг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулан, ажлын амжилт гаргасан, бүтээл нь өмнөх түвшнээс

ахисан, сахилгын болон ёс зүйн зөрчилгүй иргэнд шагналыг яам, Засгийн газрын гэсэн дарааллаар олгоно.

3.2. Засгийн газрын шагналыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 2.2-т заасны дагуу 12-оос доошгүй жил ажилласан, энэхүү журмын 3.1; 3.8-д заасан шаардлагыг тус тус хангасан иргэнд, яамны шагналыг боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хамт олноо манлайлан ажилласан энэхүү журмын 3.1-д заасан шаардлагыг хангасан иргэнд тус тус олгоно.

3.3. Шагналыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 2.5-д заасан өдөр, тухайн салбарын 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай тэгш ой, болон салбарын дор дурдсан тэмдэглэлт өдрийг тохиолдуулан тус тус олгоно.

3.3.1. "Боловсролын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр Дэлхийн /Монголын/ багш нарын өдөр; (жил бүрийн 10 дугаар сарын 05-ны өдөр);

3.3.2. Соёлын тэргүүний ажилтан", "Ардын авьяастан" хүндэт тэмдгээр Соёл, урлагийн ажилтны өдөр (жил бүрийн 9 дүгээр сарын 2 дахь Ням гараг);

3.3.3. Шинжлэх ухааны хүндэт тэмдгээр Шинжлэх ухааны ажилтны өдөр (жил бүрийн 11 дүгээр сарын 4 дүгээр долоо хоногийн Ням гараг);

3.3.4. Биеийн тамир, спортын хүндэт тэмдгээр Тамирчдын өдөр (жил бүрийн 6 дугаар сарын 4 дүгээр долоо хоногийн Ням гараг);

3.3.5. "Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч" тэмдгээр Үндэсний бичиг үсгийн баяр (жил бүрийн 5 дугаар сарын эхний Ням гараг);

3.4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны жуух бичгийг энэхүү журмын 3.3-т заасан өдөр олгоно.

3.5. Салбарын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэгч анхан шатны байгууллага дор дурдсан баримт бичгийг баяр, тэмдэглэлт өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө журмын 3.6-д заасан байгууллагад гаргана. Шагналд нэр дэвшүүлэхдээ өмнө шагнагдсан яам болон Засгийн газрын шагналаас хойш 3-аас доошгүй жил тухайн салбартаа тогтвортой ажиллаж, ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшнээс өссөн эсэхийг харгалзана.

3.5.1. Шагнуулах тухай хүсэлт гаргасан байгууллагын албан бичиг;

3.5.2. Хамт олны хурлын тэмдэглэл;

3.5.3. Ажил байдлын дэлгэрэнгүй тодорхойлолт, бүтээлийн жагсаалт;

3.5.4. Батлагдсан загварын дагуу танилцуулга, анкет;

3.5.5. Яамны болон төр засгийн бусад шагналаар шагнагдсан бол тэдгээрийг гэрчлэх үнэмлэхний хуулбар;

3.5.6. "Шинжлэх ухааны хүндэт тэмдэг" шагналд нэр дэвшигч нь бүтээлийн жагсаалт болон патент, ашигтай загварын гэрчилгээ, докторын зэрэг хамгаалуулсныг нотлох баримт;

3.6. Шагналд нэр дэвшүүлэгч анхан шатны байгууллага нь дараах шатны холбогдох дээд байгууллагад уламжилна.

3.6.1. Боловсрол болон соёлын салбарын тэргүүний ажилтан, "Ардын авьяастан", "Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч" тэмдэг, яамны "Жуух бичиг"-т нэр дэвшигчийн ажиллаж байгаа, ахмад ажилтан бол өндөр насны тэтгэвэрт гарах хүртэл ажиллаж байсан албан байгууллагын харьяалагдах нутаг дэвсгэрийн боловсрол, соёл, урлагийн байгууллага /аймаг, нийслэлийн боловсрол, соёл, урлагийн газар, их дээд сургууль бол Их, дээд сургуулиудын консерциум/-аар;

3.6.2. "Шинжлэх ухааны хүнтэт тэмдэг"-т нэр дэвшигчийн баримт бичгийг яамны шинжлэх ухааны бодлогын нэгжээр;

3.6.3. "Биеийн тамир, спортын хүнтэт тэмдэг"-т нэр дэвшигчийг тухайн байгууллагын харьяалагдах нутаг дэвсгэрийн /аймаг, нийслэлийн/ биеийн тамир, спортын газраар;

3.6.4. Журамд заасан шаардлагыг бүрэн хангасан, ямар нэг байгууллагад харьяалагддаггүй иргэнийг харьяалах баг, хороо, төрийн бус байгууллага нь тус тус шагналд тодорхойлж, энэхүү журмын 3.6.1-3.6.3-д заасан холбогдох дээд газраар уламжлуулахаар хүргүүлнэ.

3.7. Нэр дэвшүүлэгч 3.6-д дурдсан байгууллага нь баяр, тэмдэглэлт өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шагналд нэр дэвшигчийн мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн систем (www.esis.edu.mn)-д цахим хэлбэрээр мэдүүлэн, журмын 3.4-д заасан баримт бичгийг архивын түр хадгалах нэгж үүсгэн хадгалж, журмын 1 дүгээр хавсралтын дагуу холбогдох мэдээллийг албан бичигт хавсарган ирүүлнэ.

3.8. Монгол Улсын Засгийн газрын болон яамны шагналаар шагнахад энэхүү журмын 3.1 зааснаас гадна салбарын онцлог болон дараах шаардлагыг хангасан байдлыг харгалзан үзнэ.

3.8.1. "Боловсролын тэргүүний ажилтан" (БТА) хүндэт тэмдгээр:

а. Ажил мэргэжлийн ур чадвар, мэргэшлийн түвшин нь сүүлийн жилүүдэд тогтвортой өссөн үзүүлэлттэй бөгөөд багш, ажилтны дунд зохиогддог Улсын чанартай уралдаан, тэмцээнд эхний 3 байрт шалгарсан багш;

б. Тэргүүн туршлагаа аймаг, нийслэлийн хэмжээнд амжилттай түгээн дэлгэрүүлсэн нь холбогдох дээд шатны байгууллага /Багшийн мэргэжил дээшлүүлэх

институт, Нийслэлийн боловсролын газар, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар/-ын тодорхойлолтоор баталгаажсан багш, боловсролын салбарын удирдах ажилтан;

3.8.2. "Соёлын тэргүүний ажилтан" (СТА) хүндэт тэмдгээр:

а. Улсын чанартай уралдаанд амжилттай оролцож, эхний 3 байрт шалгарсан уран бүтээлч;

б. Мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол бүжигчин, гимнастик, акробат, уран нугараач, хүч тамирын жүжигчин, зэрлэг ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийч, үлээвэр хөгжимчнөөр 10 жил ажилласан уран бүтээлч;

в. Салбарт ажилласан жил, жуух бичгээр шагнагдсан эсэхийг үл харгалзан Дэлхийн хэмжээний соёл, урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэн, номын яармагт болон олон улсын мэргэжлийн байгууллагаас зохион байгуулдаг олон нийтийн рейтинг тогтоох албан ёсны санал асуулга /уралдаан/-д оролцон тус тус эхний 3 байрт шалгарсан соёл, урлагийн ажилтан, уран бүтээлч;

г. 1990 оноос өмнө Улсын тэргүүний уран сайханч болсон, улс, олон улсын их наадмын алт /мөнгө, хүрэл/ медаль хүртсэн тус салбарт ажиллаж байгаа уран бүтээлч;

3.8.3. "Шинжлэх ухааны тэргүүний ажилтан" (ШУТА) хүндэт тэмдгээр:

а. Эрдэм шинжилгээний бүтээл нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, олны хүртээл болсон зэргээр шинжлэх ухааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан эрдэмтэн, судлаач;

б. Шинжлэх ухааны салбарын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэхэд зохих хувь нэмэр оруулсан, 3 болон түүнээс дээш судлаачийн эрдмийн ажлыг удирдаж, докторын зэрэг хамгаалуулсан, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэгч, их дээд сургуулийн эрдэмтэн багш, судлаач;

в. Шинэ бүтээл, оновчтой санаачилга гарган улс эх орны өмнө тулгамдсан асуудлыг шинжлэх ухаан, технологийн ололтод түшиглэн шийдсэн инженер, зохион бүтээгч, эрдэмтэн судлаач;

г. Монгол Улсын шинжлэх ухааны салбарын хөгжил, салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэхэд бодитой хувь нэмэр оруулсан гадаадын иргэн;

3.8.4. "Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан" (БТСТА) хүндэт тэмдгээр:

а. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд бодитой хувь нэмэр оруулж, бэлтгэсэн тамирчид нь улс, олон улсын тэмцээн наадамд удаа дараа медальт байрт шалгарсан багш, дасгалжуулагч;

б. Олимп, тив, дэлхийн тэмцээн, наадамд өндөр амжилт гаргасан, тив, дэлхий, улсын рекордыг шинэчлэн тогтоосон тамирчин;

3.8.5 “Ардын авьяастан” (АА) хүндэт тэмдгээр:

а. Дуу, хөгжим, бүжиг, оёдол, хатгамал, уран зураг, баримал, сийлбэр, цутгамал, хөөмөл зэрэг ардын урлагийн тодорхой төрлөөр мэргэшин, уран бүтээл туурвин, сурталчилж олны хүртээл болгосон мэргэжлийн бус уран бүтээлч, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, урлагийн тодорхой төрлийг эзэмшин, түгээн дэлгэрүүлж байгаа иргэн;

б. Соёлын биет бус өвийг өвлөн уламжилж, түгээн дэлгэрүүлж байгаа / i) эх хэл, аман уламжлал, ii) ардын язгуур урлаг, iii) уламжлалт гар урлал, iv) байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, уламжлалт арга технологи/-ийг өвлөн уламжилж, түгээн дэлгэрүүлж, түүнийгээ олны хүртээл болгосон бөгөөд 10 түүнээс дээш шавь нь тухайн төрлөөр тодорхой амжилт гаргасан авьяаслаг иргэн, уран бүтээлч, биет бус өвийг өвлөн уламжлагч;

в. Олон улсын болон үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан ардын урлагийн наадмын эхний 3 байр эзэлсэн уран бүтээлч, иргэн;

3.8.6 “Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч” (ҮБСД) тэмдгээр:

Бичиг үсгийн үнэт дурсгал, Монгол бичгийг дээдлэх, түгээн дэлгэрүүлэх үйлсэд амжилт гаргаж, тодорхой үр дүн бий болгосон үндэсний бичгээр аймаг, хот, улсын хэмжээнд онцгой амжилт, бүтээл гаргасан багш, судлаач, бичиг соёлын зүтгэлтэн, иргэн;

Дөрөв. Шагналыг шийдвэрлэх, олгох

4.1. Яамны шагналын асуудал хариуцсан албан хаагч нь энэ журмын шаардлагад нийцсэн баримт бичгийг шагналын комиссоор хэлэлцүүлнэ. “Шагналын комиссын дарга нь Төрийн захиргааны асуудал эрхэлсэн нэгжийн дарга, комисст салбар тус бүрийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга нар, нарийн бичгийн даргаар шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

4.2. Шагналын баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь нотлогдсон тохиолдолд, баримт бичгийг буцаах ба нэр дэвшсэн тухайн албан хаагчийн шагнал олгох асуудлыг 3 жилийн хугацаанд ахин хэлэлцэхгүй.

4.3. Шагналын комиссын гишүүдийн олонхийн санал авсан иргэнд сайдын шийдвэрээр шагнал олгож, шагналыг энэхүү журмын 3.6-д заасан байгууллагад хүлээлгэн өгнө.

Тав. Тэмдэг, үнэмлэхийг нөхөн болон сольж олгох

5.1 Шагналын тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсний улмаас нөхөн авах тохиолдолд дор дурдсан баримт бичгийг бүрдүүлэн яаманд ирүүлнэ.

5.1.1. Өргөдөл/албан бичиг

5.1.2. Иргэний үнэмлэхний хуулбар

5.1.3. Шагналын үнэмлэхний хуулбар

5.1.4. Үнэмлэх, жуух нь үрэгдсэн бол шагнасан тухай шийдвэрийн хуулбар

5.1.5. Мөнгө тушаасан баримт

5.2 Нөхөн авах хүсэлт гаргасан байгууллага, албан хаагч, иргэн нь салбарын шагналын тэмдэг үрэгдүүлж нөхөн авахад 20 000 /хорин мянга/ төгрөг, үнэмлэх, жуух бичгийг нөхөн авахад тус бүр 10 000 /арван мянга/ төгрөг төлнө.

---oOo---

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын шагналын журмын нэгдүгээр хавсралт

ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН ХҮСНЭГТ

№	Овог нэр	Байгууллагыг харьяалах аймаг/ нийслэл	Одоо ажиллаж байгаа газар, албан тушаал	Мэргэжил	РД	Нас хүйс	Ажилласан жил			ЗГ, яамны болон бусад холбогдох шагнал авсан огноо	Ямар, шагналд хаанаас тодорхойлсон	Шагнуулах үндэслэл	Дэмжсэн санал /хувиар/
							Салбарт	Нийт					
1													
2													

Тайлбар: Байгууллагыг харьяалах аймаг/ нийслэл гэдэгт нэр дэвшигчийг шагналд тодорхойлсон газар, байгууллагын харьяалагдах нутаг дэвсгэрийн нэрийг бичнэ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын шагналын журмын хоёрдугаар хавсралт

ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ АЖИЛТНЫ АНКЕТ

1. Овог:
2. Нэр:
3. Регистрийн дугаар:
4. Нас:
5. Хүйс:
6. Яс үндэс:
7. Бүртгэлтэй хаяг:
8. Ажлын газрын үндсэн захиргаа:
9. Боловсрол, мэргэжил эзэмшсэн байдал /он дарааллаар/

3x4 зураг

№	Төгссөн сургууль	Суралцсан хугацаа	Эзэмшсэн боловсрол, мэргэжил
1			
2			
3			

10. Ажил эрхэлсэн байдал /он дарааллаар/

№	Ажлын газрын нэр	Ажилласан хугацаа /он, сараар/	Эрхэлсэн ажил албан тушаал
1			
2			
3			
4			

11. Нийт ажилласан жил:
12. Үүнээс тухайн салбарт ажилласан жил:
13. Шагнагдаж байсан шагналууд /он цагийн дараалал баримтлан бичих бөгөөд Яамны бусад шагналаар шагнагдсан бол түүний **хуулбарыг заавал хавсаргана.**/

№	Шагналын нэр	Шагнал, үнэмлэхийн дугаар	Шагнагдсан он
1			
2			

14. Шагнуулах үндэслэл: /Товч, тодорхой бичнэ/

.....
.....
.....
.....
.....

15. Шагнуулахад онцгойлон харгалзаж үзэх амжилт:

.....
.....
.....

16. Ямар шагналд нэр дэвшүүлж буй санал:

17. Хамт олны саналын хувь:


18. Шагналыг хүлээн авах /байгууллагын/ хариуцсан ажилтны нэр, утасны дугаар, мэйл хаяг:

.....,

..... дарга, захирал, эрхлэгч	 гарын үсэг, тамга тэмдэг	/...../ гарын үсгийн тайлал
----------------------------------	--------------------------------------	--------------------------------

---oOo---

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2019 оны 12 дугаар
сарын 20-ны өдрийн 4/828 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ШАГНАЛ
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЛБАРЫН
ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН ХҮНДЭТ ТЭМДГИЙН ЗАГВАР


Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг нь дараах техникийн тодорхойлолтыг хангасан байна. Үүнд:

1. **“Боловсролын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг”** нь /гагнуур тогтохуйц зэс, төмөр/ металл, дүрслэл нь бүхэлдээ эрдэм боловсрол нарны цацраг адил түгэн дэлгэрэхийн бэлэгдлийг агуулсан байна. Тэмдэг нь ромбо хэлбэртэй, эргэн тойрон шар, цагаан хүрээтэй, тэмдгийн дээд хэсэгт улаан дэвсгэр дээр соёмботой, дунд хэсэгт хөх дэвсгэр дээр **“Боловсролын тэргүүний ажилтан”** гэж Кирилл үсгээр бичиж, доор нь цагаан өнгөтэй дэлгэмэл ном дүрсэлсэн, дээд болон доод хэсгийн улаан дэвсгэр дээр нарны цацрагийг бэлгэдсэн алтан шар өнгийн зураастай, урт нь 45мм, өргөн нь 25мм, зузаан нь 2мм байна. Тэмдгийн ар талд тогтоогч зүүтэй, зүүний доод хэсэгт гялгар метал гадаргуу дээр БТА-..... тэмдгийн дугаарыг бичсэн байна.
2. **“Соёлын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг”** нь /гагнуур тогтохуйц зэс, төмөр/ металл, дүрслэл нь бүхэлдээ монгол хүмүний ариун цагаан авьяас билгээр дэлхийн болон үндэсний соёл урлаг баяжин хөгжиж, мандан бадарч байхын бэлэгдлийн агуулсан байна. Тэмдэг нь ромбо хэлбэртэй, эргэн тойрон шар, цагаан хүрээтэй, тэмдгийн дээд хэсэгт улаан дэвсгэр дээр соёмботой, дунд хэсэгт **“Соёлын тэргүүний ажилтан”** гэж Кирилл үсгээр бичсэн, доод хэсэгт дэлгэмэл ном дээр хөгжмийн дүрсийг дүрсэлсэн, тэмдгийн доод хэсгийг цэнхэр өнгөөр давхар эмжсэн 2-3 мм хүрээ гаргасан байна. Урт нь 45мм, өргөн нь 25мм, зузаан нь 2мм байна. Тэмдгийн ар талд тогтоогч зүүтэй, зүүний доод хэсэгт гялгар метал гадаргуу дээр СТА-..... тэмдгийн дугаарыг бичсэн байна.
3. **“Шинжлэх ухааны тэргүүний ажилтан хүндэт тэмдэг”** нь /гагнуур тогтохуйц зэс, төмөр/ металл, дүрслэл нь бүхэлдээ байгаль дэлхий, юмс үзэгдэл, бодис, одон орон, түүх соёлын шинжлэлийг монгол ухаанаар баяжуулан хөгжүүлэхийн бэлэгдлийг агуулсан. Тэмдэг гонзгой хэлбэртэй, хүрээ нь дээд хэсэгтээ цэнхэр, дунд хэсэгтээ алхан хээ бүхий хөх, доод хэсэгтээ ногоон өнгөөр эмжсэн давхар хүрээтэй байна. Тэмдэг нь бүхэлдээ алтан шар дэвсгэртэй байх ба дээд хэсэгт соёмботой, дунд хэсэгт

“Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” гэж монгол бичгээр бичиж, доод хэсэгт шинжлэх ухааны бэлэг тэмдгийн дүрстэй, урт нь 45мм, өргөн нь 25мм, зузаан нь 2мм байна. Тэмдгийн ар талд тогтоогч зүүтэй, зүүний доод хэсэгт гялгар метал гадаргуу дээр ШУТА-..... тэмдгийн дугаарыг бичсэн байна.

4. **“Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг”** нь /гагнуур тогтохуйц зэс, төмөр/ металл, дүрслэл нь бүхэлдээ алтан шаргал амжилтын тууз бүхий зуйван дугуй хэлбэртэй, хоёр талаараа нааш товгор байдалтай амжилтын навч хүрээлнэ. Дунд талын ялалтын бамбар товгор байх ба дүрэлзэн асах галын дөл нь улаан өнгөтэй байна. Арын хэсэг нь мандан бадрахын бэлгэдэл алтан нарны цацраг бүхий товгор дүрс, дээд талын орой хэсэгт хар хөх өнгийн 10 мм-ийн диаметртэй дугуй дотор алтан соёмбо байх ба хүрээ нь алтан шар байна. Суурь хэсгийн алтан шаргал туузны дүрс бүхий дэвсгэр дээр хар өнгөөр **“Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан”** гэж Үндэсний /Монгол/ бичгээр бичнэ. Урт нь 50мм, өргөн нь 30мм, зузаан нь 2-3мм байна. Тэмдгийн ар талд тогтоогч зүүтэй, зүүний доод хэсэгт гялгар метал гадаргуу дээр БТСТА-..... тэмдгийн дугаарыг бичсэн байна.
5. **“Ардын авьяастан хүндэт тэмдэг”** нь /гагнуур тогтохуйц зэс, төмөр/ металл, дүрслэл нь бүхэлдээ ардын урлагийн бүх төрөл наран цацрах мэт мандан бадрах бэлэгдэлтэй. Тэмдэг нь 2 хэсгээс бүрдэнэ. Үндсэн хэсэг нь дугуй хэлбэртэй, алтан шар өнгөтэй, нарны цацрагийг бэлэгдсэн товгор 8 талт том цацраг хээ тус бүрийн хооронд 4 ширхэг жижиг цацраг бүхий хүрээтэй, тэмдгийн голд 25 мм голчтой, 3 мм-ийн давхар хүрээ бүхий дэвсгэрийг голлуулан ухаж, морин хуурчийн дүрсийг гарган, дээл, малгай, хуурын толгойг хөх өнгөөр дүрсэлж, давхар хүрээний доод хэсэгт **“Ардын авьяастан”** гэж Кирилл үсгээр, хөх өнгөөр бичнэ. Үндсэн хэсгийн диаметр нь 35 мм, зузаан нь 2мм байна. Зүүлт бүхий 2 тэгш өнцгийн үндсэн хэсэгтэй холбогдох сэнжний хэсэг нь доош мохоо өнцөг үүсгэсэн гоёмсог хэлбэртэй байх ба алтан шар өнгийн хүрээтэй, улаан өнгөтэй дэвсгэрийн доод хэсэгт мандан бадрахын бэлэгдэл галын дөлийг дүрсэлсэн байна. Тэмдгийн зүүлт хэсгийг үндсэн хэсэгтэй гогцоо цагиргаар холбож, ар талд тогтоогч зүүтэй, үндсэн хэсгийн арын гялгар метал гадаргуу дээр ТАА-..... тэмдгийн дугаарыг бичсэн байна.
6. **“Тэмдгийн хайрцаг”** нь гадна талаараа хөх цэнхэр өнгөтэй, 80х70х28мм хэмжээтэй, нүүрэн дээрээ боронзон өнгөөр алтан соёмбыг голлуулан дүрсэлсэн байна. Хайрцгийн дотор талын дээд хэсэг цагаан торгомсог өнгөөр доторлосон, суурийг хөх өнгийн хамба хилэн материалаар өнгөлсөн зөөлөвчтэй, тухайн тэмдэг болон тэмдгийн ар талын зүү байрлах ухлаадастай байна.
1. **“Тэмдгийн бүрэлт”** нь тэргүүний ажилтан, ардын авьяастан хүндэт тэмдэг/ 14К алтны уусмалаар бүрсэн. Арилдаггүй паалан буюу метал гадаргуу дээр халааж тогтоодог будаг байх бөгөөд гагнах температурт тэсвэртэй, тэмдгийн өнгө чанарыг хадгална. Арын тогтоогч нь чанар сайтай зориулалтын зүү байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2019 оны 12 дугаар
сарын 20-ны өдрийн 4/828 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ЖУУХ БИЧГИЙН ЗАГВАР

Яамны жуух бичиг нь дараах техникийн тодорхойлолтыг хангасан байна.

Үүнд:

"Жуух бичиг" нь 297х210мм хэмжээтэй хуудсыг А5 хэмжээгээр 2 нүүрт хуваан, тус бүрийг 10мм өргөн түмэн насан хээгээр хүрээлсэн байна. Хүрээний дотор хэсгийг нийтэд монгол үндэсний билэгдэлт хээгээр дэвсгэрлэн чимэглэсэн байна. 1 дүгээр нүүрт дээд хүрээнээс доош 20мм зайд 60х30мм хэмжээтэй соёмбо, соёмбоос доош 50мм зайд голлуулан **"Дугаар..."** гэж бичсэн байна.

Үндсэн бичвэр нь: 2 дугаар нүүрэнд хүрээнээс доош 30мм зайд нүүрийг голлуулан "Хүндэт..... Таныг " гэсэн үгийг байрлуулна. Түүний доор 15мм зайд **"Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарыг хөгжүүлэх үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг тань үнэлж, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны "ЖУУХ БИЧИГ"-ээр шагнав"** гэсэн өгүүлбэрийг бичсэн байна. Уг өгүүлбэрээс доош 30мм зайд **Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд** /нэр/ байна. Мөн 2 дугаар нүүрийн доод хэсэгт **20.... оны ... сарын ны өдөр Улаанбаатар хот** гэсэн бичвэрийг голлуулан бичнэ.

Бүх бичвэр хар өнгөтэй, бичмэл хэвээр бичсэн байна.